

## “Нээлттэй Сэлэнгэ” хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 21 дүгээр зүйлийн 21.1, 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.“Нээлттэй Сэлэнгэ” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, нэгдсэн удирдлагаар хангаж, хөтөлбөрийн биелэлтийн явц болон хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2 жил тутам аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Н.Лхагвадорж/-д даалгасугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ

А.ДАШБАТ

## **“НЭЭЛТТЭЙ-СЭЛЭНГЭ” ХӨТӨЛБӨР**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

“Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого” УИХ-аар батлагдаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус бодлогын баримт бичигт боомт, эрчим хүч, аж үйлдвэржилт, хот хөдөөгийн тэнцвэрт хөгжил, ногоон хөгжил, төрийн бүтээмж зэрэг 6 багц асуудал туссан.

Шинэ сэргэлтийн бодлогын Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд орон нутгийг хөгжүүлэх, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагуудыг дэмжих зорилгоор “Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 419 дүгээр тогтоол, Засгийн газрын хуралдааны 56 дугаар тэмдэглэл гарсан.

Дээрх шийдвэрүүдийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 157-р захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн 2022-2024 онд хэрэгжүүлэх ажлын ерөнхий төлөвлөгөөгөөр салбарын яам, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн авч хэрэгжүүлэх ажлын чиглэлүүдийг баталсан.

Энэ хүрээнд аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/478 тоот “Ажлын хэсэг байгуулах тухай” захирамжаар Улаанбаатар хотоос Сэлэнгэ аймагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийг дэмжих бодлого боловсруулах ажлын хэсгийг томилон ажиллуулж байна.

Монгол Улсын Засгийн газраас зохион байгуулсан “Хөдөөгийн сэргэлт” үндэсний чуулганд манай аймаг оролцож, аймгийн онцлог, давуу тал, боломжийг чуулганд оролцсон 1400 гаруй оролцогч нарт танилцуулж, улсын хэмжээнд аймгаа сурталчлах ажлыг хэрэгжүүллээ.

Нутгийн удирдлагын байгууллага, бүх шатны хурлын Төлөөлөгчид, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санаачилга, оролцоотойгоор “Алсын хараа-2050 урт хугацааны бодлого”, “Шинэ сэргэлт”-ийн бодлогын үзэл баримтлалыг нийтэд сурталчлан таниулах ойлгуулах, аймаг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор Сэлэнгэ аймаг нь “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 40 багц цагийн сургалтыг зохион байгуулж, аймгийн ИТХ-ын төлөөлөгч болон 200 төрийн албан хаагчийг хамруулсан сургалтыг зохион байгуулж мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан.

Иймд манай аймаг орон нутгийн өнөөгийн нөхцөл байдал, нөөц боломж, аймгийн түүх, соёл, зан заншил, уламжлал, нийгэм, эдийн засаг, техник, технологи, үндэсний үйлдвэрлэлийн ололт амжилтыг шилжин ирэх иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд мэдээлэн сурталчлах “Нээлттэй Сэлэнгэ хөтөлбөр”

(цаашид “Хөтөлбөр” гэх)-ийг холбогдох бодлогын бичиг баримт, хөтөлбөр, үйл ажиллагааг үндэслэн боловсруулсан болно.

### **Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим**

2.1.1. Монгол Улсын хууль, хөгжлийн бодлогын баримт бичиг, холбогдох үндэсний хөтөлбөрүүд, аймаг орон нутгийн бодит нөөц бололцоо, бүс нутгийн эдийн засгийг кластержуулан хөгжүүлэх, орон нутаг өөрийгөө бие даан санхүүжүүлэх эдийн засгийн бодлогод тулгуурлах;

2.1.2. Хөтөлбөрийн агуулгад аймаг орон нутагт шилжин ирж ажиллаж, амьдрах үйл ажиллагаа эрхлэн явуулахад үүсэх давуу тал болон үүсч болзошгүй хүндрэл бэрхшээлийг зөв тооцож тусгахыг эрмэлзэн мэдээллийг нээлттэй, тэгш, хүртээмжтэй түгээхийг чухалчилсан, хувь хүн, ААН, байгууллагад хуулиар олгогдсон эрхийг дээдлэн хүндэтгэсэн, үүрэг хариуцлагыг ухамсарлуулан таниулж хандлагын өөрчлөлтөд уриалсан, бизнесийн орчны тэгш боломж, шударга өрсөлдөөнийг эрхэмлэсэн, хөгжил дэвшил, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын таатай орчин, олон талт харилцааны онцлогуудыг уялдуулан тодорхойлсон байх;

2.1.3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд иргэд олон нийт, аж ахуйн нэгж, байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, бизнесийн болон мэргэжлийн холбоодын оролцоог түлхүү дэмжих;

### **Гурав. Хөтөлбөрийн зорилго**

3.1. “Хот, хөдөөгийн сэргэлт” бодлогын зорилтыг хангах, Сэлэнгэ аймагт шилжин ирж суурьшин ажиллаж амьдрах, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг угтан авахад шаардагдах бэлтгэлийг хангах, шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийг дэмжих

### **Дөрөв. Хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

**Зорилт-1.** Сэлэнгэ аймагт амьдрах таатай орчин бүхий давуу тал, боломж нөхцөлийг Улаанбаатар хотын иргэд, залуучуудад сурталчлах ажлыг зохион байгуулна.

- 1.1. Монгол Улсын Засгийн газар болон Сэлэнгэ аймгаас хэрэгжүүлж буй орон нутагт чиглэх шилжилт хөдөлгөөний бодлого, дэмжлэг, урамшууллыг олон нийтэд таниулах
- 1.2. Улаанбаатар хотоос ирж сэлгэн ажиллах төрийн албан хаагчдад үзүүлэх дэмжлэг, хөнгөлөлтийг тодорхойлж олон нийтэд хүргэх
- 1.3. Сэлэнгэ аймгийн бизнесийн орчны давуу тал, боломж, хөнгөлөлт дэмжлэгийн талаарх мэдээллийг “Нээлттэй-Сэлэнгэ” цахим хуудсанд байршуулан сурталчлах

- 1.4. Сэлэнгэ аймгийн түүх соёлын дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газрууд, цэвэр агаар, ундны усны нөөц, ой, ургамал, ан амьтны зэрэг байгалийн унаган төрхийг харуулсан контент гаргах
- 1.5. Улаанбаатар хотод амьдран суудаг нутгийн ахмад настнуудад чиглэсэн "Хүн байгалийн хүйн холбоо-Унасан газар угаасан ус" арга хэмжээ зохион байгуулах
- 1.6. Их дээд сургууль, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, поль техникийн коллежийг төгсөж Улаанбаатар хот болон өөр аймаг, орон нутагт амьдарч буй хөдөлмөрийн насны иргэдийг хамарсан "Нутгаа зорьё" өдөрлөг зохион байгуулах
- 1.7. "Нээлттэй Сэлэнгэ" арга хэмжээг Улаанбаатар хотод зохион байгуулах
- 1.8. Сэлэнгэ аймгийн Нийгэм, эдийн засгийн өсөлт, бууралтын динамик загвар гаргах
- 1.9. "Эдийн засгийн" форум арга хэмжээг зохион байгуулах
- 1.10. "Нутагтаа сайхан амьдаръя" аяныг өрнүүлж, сум, орон нутгийн иргэдийг тогтвор суурьшилтай байх бодлогоор дэмжих

**Зорилт-2.** Сэлэнгэ аймагт шилжин ирж суурьшин амьдарч байгаа иргэн, өрх гэр бүл, аж ахуйн нэгжийг дэмжин сурталчлах, олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулна.

- 2.1 Сэлэнгэ аймагт шилжин ирж суурьшин амьдарч байгаа иргэн, өрх гэр бүл, аж ахуйн нэгжийг олон нийтэд мэдээлэх, сурталчилах ажлыг тухай бүр зохион байгуулах
- 2.2 Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бэлтгэн нийлүүлэх, боловсруулах чиглэлээр шинээр байгуулах үйлдвэрийг татвараас чөлөөлөх
- 2.3 Их, дээд сургуулиудад суралцаж байгаа оюутан залуучуудыг орон нутагтаа ирж ажиллах, нөхцөл боломжоор хангах дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах гэрээ байгуулах
- 2.4 Дэвшилтэт технологи, инновацийг үйлдвэрлэл, үйл ажиллагаандаа нэвтрүүлж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг дэмжиж сурталчлах
- 2.5 Сум болгон өөрийн онцлог, давуу талыг сурталчилсан цахим танилцуулга, мэдээлэл бэлтгэж олон нийтэд хүргэх

**Зорилт-3.** Орон нутагт цахим тогтолцоог шинэчилж, бүртгэл мэдээллийг сайжруулна.

- 3.1 "Нээлттэй Сэлэнгэ" аппликейшн нэвтрүүлж, иргэдэд сурталчлах
- 3.2 Төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүнд сурталгүй ёс зүйтэй болгох аян зохион байгуулах
- 3.3 Аймгийн хэмжээний төрийн албаны сул орон тоо, нэн шаардлагатай байгаа мэргэжилтэй ажилтанд үзүүлэх хөнгөлөлт дэмжлэгийг сум, байгууллага бүрээр гарган олон нийтэд танилцуулж, мэдээллээр хангах

- 3.4 Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын Ejob платформыг иргэдэд сурталчлан таниулж, ажиллах хүчний нөөц болон сул ажлын орон тоог сар бүр шинэчлэн иргэдэд цахимаар мэдээллэх
- 3.5 Аймгийн хэмжээнд иргэдэд эзэмшүүлэх газрын жил бүрийн төлөвлөлтийг нэгтгэж, олон нийтэд цахимаар мэдээллийг түгээх, тогтмол хангах, газар олголтыг нээлттэй ил тод явуулах

**Зорилт-4.** Малын механик өсөлтөөс бусад орон нутгийн хөгжлийг дэмжсэн аж үйлдвэр, аялал жуулчлал, ногоон хөгжил, эрчимжсэн хөдөө аж ахуйг хөгжүүлж ажлын байрыг нэмэгдүүлнэ.

- 4.1 Сэлэнгэ аймгийг хоггүй аяллын бүс болгон эко аялал жуулчлалыг хөгжүүлэх
- 4.2 Орон нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэн ажлын байрыг нэмэгдүүлэх
- 4.3 “Өрх бүр үйлдвэрлэгч” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх
- 4.4 Хөдөө аж ахуйн түүхий эдийг /арьс, шир, дайвар бүтээгдэхүүн/ анхан шатны боловсруулалт хийх үйлдвэр барих, ажлын байр нэмэгдүүлэх
- 4.5 Хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх боловсруулах үйлдвэр байгуулах
- 4.6 Малчдын хоршоо, сумдад баригдаж буй бяслагны үйлдвэрийг түшиглэн сүү цагаан идээ боловсруулах цехүүдийг бий болгож кластерийн нэгдсэн системээр борлуултын нэгдсэн суваг үүсгэх
- 4.7 Эрүүл агаарт сувилуулах, аялаж амрах төв байгуулахад бодлогоор дэмжлэг үзүүлэх
- 4.8 “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд жимс, жимсгэний аж ахуй эрхлэгч иргэн, ТББ, аж ахуйн нэгжийг дэмжиж газар олгох, хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөрт хамруулах
- 4.9 Жимс, жимсгэний аж ахуй, эм, цайны ургамал тариалах боломжтой газрын судалгааг гаргаж, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж ААН, нөхөрлөл, хоршоодод газар олгох, урамшуулах зэргээр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах
- 4.10 Загас үржүүлэх, цөөрмийн загасны аж ахуй байгуулах боломжтой газруудад хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих,
- 4.11 Энгийн болон аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах иргэн, ААН-ийг дэмжих
- 4.12 Алтанбулаг, Сүхбаатар суманд “Жуулчны гудамж” байгуулах, жуулчдыг татах бүтээгдэхүүн, үйлчилгээ эрхлэх иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжих
- 4.13 Орон нутагт шилжин ирэгсдийг ажилд авсан жижиг, дунд үйлдвэрт хөнгөлөлттэй зээл олгохыг бодлогоор дэмжих

**Зорилт-5.** Сэлэнгэ аймагт тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг сайжруулж амьдралын таатай орчин бүрдүүлнэ.

- 5.1 Төвлөрсөн, эко орон сууцны хорооллыг байгуулах, Дулааны алдагдал багатай, пассив байшин, сууц, стандарт 00 барих, зөвлөгөө өгөх иргэн, аж ахуйн нэгжийг дэмжиж хамтран ажиллах
- 5.2 Гэр бүл, хүүхэд залуучуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх ногоон байгууламж, соёлын цогц үйлчилгээтэй цэцэрлэгт хүрээлэн байгуулах
- 5.3 Гарааны бизнес эрхлэгч залуучуудын инноваци шингээсэн төслийн шинэ санал, санаачлагыг бодлогоор дэмжих
- 5.4 Иргэн, аж ахуйн нэгжид үзүүлэх зээлийн бодлогыг орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банкуудтай хамтран хэрэгжүүлэх
- 5.5 Орон нутагт их дээд сургуулийн харьяа сургууль байгуулах, Политехникийн коллежийг өргөтгөх
- 5.6 Политехникийн коллежид орон нутгаас элсэгчдийг нэмэгдүүлэх, төгсөгчдийг ажлын байраар бүрэн хангахад хувийн хэвшилтэй хамтран ажиллах, гарааны бизнесийг хөгжүүлэх хөтөлбөрт хамруулах,
- 5.7 Залуучуудын хөгжлийн төвийг сумдад байгуулах

**Зорилт -6.** Улсын бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан аймгийн хөтөлбөр, төлөвлөгөө гаргах, зарим бодлогын баримт бичгүүдэд өөрчлөлт оруулан батлаж хэрэгжүүлнэ.

- 6.1 Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих арга хэмжээний санал боловсруулах ажлын хэсгийн гишүүдийн сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулах
- 6.2 Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрүүдтэй уялдуулан аймгийн таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах

**Зорилт-7.** Төр иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлж олон нийтэд нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулна.

- 7.1 "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд улсын хэмжээнд зохион байгуулж байгаа арга хэмжээний талаар Иргэний нийгмийн байгууллагуудыг мэдээллээр хангах, уулзалт арга хэмжээг зохион байгуулах
- 7.2 Иргэний нийгмийн байгууллагуудтай үйл ажиллагааны чиглэлээс нь хамаарч хамтран ажиллах нарийвчилсан төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, бодлогоор дэмжих
- 7.3 Улаанбаатар хот, аймгуудад байгаа аймаг, сумдын нутгийн зөвлөлүүдийг татан оролцуулж, хамтран ажиллах, иргэдэд мэдээлэл өгөх
- 7.4 Орон нутгийн хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр мэргэжлийн байгууллага, холбоодтой хамтран ажиллах
- 7.5 Залуу боловсон хүчнийг орон нутагт ажиллуулах зорилгоор Залуучуудын холбоо, Оюутны холбоодтой хамтран ажиллах

7.6 Салбарын үйл ажиллагааны чиглэлээр ажиллаж байгаа ИНБ-тай хамтран хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлэх

### **Тав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

5.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулах үүрэг бүхий дэд ажлын хэсэг (цаашид “ажлын хэсэг” гэх) ажиллана. Ажлын хэсгийн ахлагч нь Монгол Улсын ерөнхий сайдын 157 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн гишүүн, аймгийн засаг даргын орлогч байна.

5.2. Ажлын хэсэг тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж аймгийн Засаг даргаар батлуулна.

5.3. Дэд ажлын хэсэг олон нийтэд мэдээлэл хүргэх, сурталчлах, үйл ажиллагааг Засгийн газрын дэргэдэх Ажлын хэсэгтэй хамтран нэгдсэн журмаар зохион байгуулах бөгөөд аймгийн хэмжээнд шинээр буй болсон ажлын байр, тухайн салбарт дутагдаж буй шаардлагатай боловсон хүчний судалгаа, шилжилт хөдөлгөөний бүртгэл зэрэг аймгийн нээлттэй мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлсэн байна.

5.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад ажлын хэсгээс тогтмол хяналт тавьж, хэрэгжилтийг дүгнэн хэлэлцэж, аймгийн Засаг дарга 2 жил тутам аймгийн ИТХ, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнана.

### **Зургаа. Хэрэгжүүлэх хугацаа**

6.1. Хөтөлбөрийг 2030 оныг дуустал хугацаанд хэрэгжүүлнэ.

### **Долоо. Хөтөлбөр хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр**

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг дараах эх үүсвэрээр бүрдүүлнэ:

7.1.1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;

7.1.2. Хөгжлийн хөтөлбөрүүд, олон улсын байгууллагын тусламжийн хөрөнгө;

7.1.3. Хувийн хэвшлийн хандив, тусламжийн хөрөнгө;

7.1.4. Бусад.

7.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу тухайн жилийн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг жил бүрийн аймгийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

### **Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт**

8.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ:

8.1.1. Хөтөлбөр хэрэгжиж дуусахад аймагт шилжин ирсэн иргэдийн бодит тоон өсөлт 20 хувиас дээш нэмэгдсэн эсэх;

8.1.2. Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, бүтээн байгуулалт, аялал жуучлал гэх мэт бүх төрлийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийн тоо;

8.1.3. Аймаг орон нутагт шинээр бий болсон ажлын байрны тоо;

8.1.4. Иргэд, ААН байгууллагууд, олон нийт рүү чиглэж тэдгээрийг татах чиглэлээр зохион байгуулсан ажлууд, түүний үр дүн;

8.1.5. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 тоот тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын “Хүн амын нэмэгдэлтийн хувь, төсвийн байгууллага, хуулийн этгээд тэдгээрийн салбар нэгжийн болон албан хаагчийн шилжилтийн хувь” шалгуур үзүүлэлтээр хэрхэн дүгнэгдсэн байдал;